



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

**Дүүргийн өвөлжилтийн
бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсгийн замын хяналтын постын халаалтын системийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор засварлан өвөлжилтийн бэлтгэлийг хангаж ажиллахыг дүүргийн Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.


2. Засварын ажилд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж, 2,237.000 (хоёр сая хоёр зуун гучин долоон мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Тус ажлыг зохион байгуулж дууссанаас хойш 14 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн менежер (Г.Дагвадорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
 2025 оны 10 дугаар сарын 08 ны өдрийн
 81 дот дугаар захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	Хөнгөн цагаан радиотар (1.2м)	ш	4	280,000	1.120,000
2	Ф25 PPR хоолой	м	50	4,500	225,000
3	Ф25 PPR троник	ш	6	1,500	9,000
4	Ф25х20 PPR троник	ш	10	1,500	15,000
5	Ф25 PPR булан	ш	14	1,500	21,000
6	Ф25х15 PPR эм үзүүртэй	ш	10	4000	40,000
7	Ф15 салдаг хаалт	ш	12	12,000	144,000
8	Ахуйн тосол	л	80	6,500	520,000
9	Ф20 PPR хоолой	м	8	3,500	28,000
10	Ф25 PPR хаалт	ш	2	17,000	34,000
11	Ф20 PPR муфьт	ш	14	1,500	21,000
12	Радиатор хий авагч	ш	4	15,000	60,000
	Нийт дүн				2.237,000